

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Боловсролын салбарын хяналт хариуцсан шинжээч, Дашпунцаг Өнөржаргал

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг" арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
1	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд "Цөөн хүүхэдтэй анги" арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих	Шалгалтад хамрагдсан цэцэрлэгийн тоо Шалгалтад хамрагдсан сургуулийн тоо	-	Шалгалтад хамрагдсан цэцэрлэгийн тоо - 105 Шалгалтад хамрагдсан сургуулийн тоо - 80	Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 134 цэцэрлэгийн 916 бүлэг шалгалтад хамрагдаж, нэг ангид байх хүүхдийн тоо нормативаас хэтэрсэн бүлгийн тоо-179 буюу 19,5 хувь, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 41 цэцэрлэгийн 320 бүлэг хамрагдаж, хүүхдийн тоо нормативаас хэтэрсэн бүлгийн тоо-68 буюу 21 хувь байна. Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын сургууль-	3-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					79, бүлэг-1977, нормативаас хэтэрсэн хүүхдийн бүлгийн тоо-605 буюу 30,6 хувь, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн тоо-40, бүлгийн тоо-2397, нэг ангид байх хүүхдийн тоо нормативаас хэтэрсэн бүлгийн тоо-322 буюу 13,4 хувь байна.		
1.2. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх							
2	Боловсролын салбарын болон хяналт шалгалтын холбогдох хууль, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгөх, хяналт шалгалтын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 22	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 5	-2025-05 дугаар сарын 06-ны өдөр Хяналт үнэлгээний үндэсний хороонд Аймгийн засаг даргын Тамгын газрын бүтцэд шинээр байгуулагдсан хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжийн дарга, албан тушаалтанд улсын байцаагчийн эрх олгох тогтоолын төсөл нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгтэй зөрчилдөж байгаа тул тогтоолын төсөлд санал хүргүүлэв. -Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн	3-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					<p>“Happy January” хөтөлбөр , арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд санал хүргүүлэв. -2025-04-17-ны өдөр "Дотоод орчны агаарын чанар" стандартын төсөлд санал өгөв. -2025-05 дугаар сарын 06-ны өдөр Хяналт үнэлгээний үндэсний хороонд Аймгийн засаг даргын Тамгын газрын бүтцэд шинээр байгуулагдсан хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжийн дарга, албан тушаалтанд улсын байцаагчийн эрх олгох тогтоолын төсөл нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгтэй зөрчилдөж байгаа тухай санал хүргүүлэв. -Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн “Happy January” хөтөлбөр , арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд санал хүргүүлэв. -2025-04-17-ны өдөр "Дотоод орчны агаарын чанар" стандартын төсөлд санал өгөв. -2025 оны 03 дугаар сарын 12-ний өдөр ЗГ-ын ХХГ-т Хяналт шалгалтын</p>		
--	--	--	--	--	---	--	--

					479 дүгээр тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 1.7, 20.2, 25.7.5 дахь заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлээ. -2025 оны 02 дугаар сард Тамхины хяналтын тухай хуулинд ерөнхий боловсролын сургуулийн орчинд электрон тамхи хориглох тухай санал өгөв.		
3	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гадаад, дотоод орчны стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа эсэхэд холбогдох байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчил арилгалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	Хяналт шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 60% Илэрсэн зөрчил арилгалтын хувь - 55% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 0	Хяналт шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 50% Илэрсэн зөрчил арилгалтын хувь - 45% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 50%	Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газартай хамтарч 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр 03-00/12, 02-00/28 дугаартай "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гадаад, дотоод орчны стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа эсэхэд холбогдох байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж батлуулж, аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр 11/1899 дугаартай албан	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					<p>бичгээр хүргүүлсэн. Хяналт шалгалтын явцын мэдээг Нийслэлийн боловсролын газар, Баян-Өлгий, Сэлэнгэ аймгаас ирүүлсэн байна. Хяналт шалгалтад нийслэлийн 111 цэцэрлэг, 41 ерөнхий боловсролын сургууль, Баян-Өлгий, Сэлэнгэ аймгийн 18 цэцэрлэг, 9 ерөнхий боловсролын сургууль хамрагдсан байна. Цэцэрлэгт аюулгүй ажиллагаанч дохиолол ажилладаггүй-48,6 хувь, гадна тоглоомын талбай, орчны аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийгээгүй-40 хувь, хүүхдийн ялгаатай хэрэгцээг хангах сургалтын хэрэглэгдэхүүнгүй-нийслэлд-40 хувь, орон нутагт-80 хувь шаардлага хангахгүй байна. Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамир, эрүүл мэнд, технологи, байгалийн ухааны хичээлийн хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага-47,5 хангагдаагүй байна. Хяналт шалгалт хийсэн объектын тоо-129, Илэрсэн зөрчил</p>		
--	--	--	--	--	---	--	--

					арилгалтын хувь - 10% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 50%.		
4	Боловсролын салбарын хяналтын чиглэлээр нийслэл, орон нутагт их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 355 объектод төлөвлөгөөт шалгалт хийх ажлыг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Албан шаардлагын хэрэгжилтийн хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 96,1% Албан шаардлагын хэрэгжилтийн хувь - 73% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 75%	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 60% Албан шаардлагын хэрэгжилтийн хувь - 50% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 65%	Улсын хэмжээнд аймагт 26 цэцэрлэг, 28 ерөнхий боловсролын сургууль, 15 ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр-15, нийслэлд-78 цэцэрлэг, 34 ерөнхий боловсролын сургууль хамрагдаж, хууль сахин мөрдөлт-64,6 хувь, эрсдэл үүсэх магадлал-33 хувьтай байна. Зөрчил арилгуулах 56 заалттай 19 албан шаардлага хүргүүлсэн байна. Хяналт шалгалтын дүнг Нийслэл, Сүхбаатар, Булган, Дорнод, Архангай, Дархан-Уул, Өмнөговь, Ховд, Өмнөговь аймгууд хагас жилээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн тоон мэдээ ирүүлсэн байна.	2-р сар, 3-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Сүхбаатар, Дундговь аймгийн боловсролын сургалтын байгууллагуудад нэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	-	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 60% (7) Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь - 60% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 45%	Боловсролын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/18 дугаар удирдамжаар Сүхбаатар аймгийн зарим боловсролын сургалтын	4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ

					<p>байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг боловсролын хяналтын чиглэлээр батлагдсан хяналтын хуудсуудад заасан асуудлын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын 5 сургуулийн үйл ажиллагааг 03/6.1-2 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 68.9%, эрсдэл үүсэх магадлалын дундаж 28.1%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-2, дунд-3, ерөнхий боловсролын 3 сургуулийн суралцагчдын дотуур байрны үйл ажиллагааг 03/6.1-5 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 73%, эрсдэл үүсэх магадлалын дундаж 25.9%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-1, дунд-2 байна. Шалгалтад хамрагдсан хүүхдийн 5 цэцэрлэгийн үйл ажиллагааг 03/6.1-1 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн</p>	<p>төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%</p>
--	--	--	--	--	---	--

					<p>дундаж 76.4%, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 23.9%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-4, дунд-1 байна. Шалгалтад Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн үйл ажиллагааг 03/6.1-3 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 47.4%, эрсдэл үүсэх магадлалын дундаж 54.2%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд “их”, 03/6.1-6 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 53.3%, эрсдэл үүсэх магадлалын дундаж 46.2%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд “дунд” байна. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 8 боловсролын сургалтын байгууллагад нийт 51 заалт бүхий улсын ахлах байцаагчийн хамтарсан албан шаардлага өгч, илэрсэн зөрчилтэй холбогдуулан Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуульд Зөрчлийн тухай хуулийн 9.11 дүгээр зүйлийн 2</p>		
--	--	--	--	--	---	--	--

					дахь заалтыг үндэслэн 500,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа.		
6	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь - 100%	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь - 100%	-2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 03-00/01 удирдамжаар Нийслэлийн ерөнхий боловсролын 131 дүгээр сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, бага ангийн багш н.Ундармааг сургуулийн ёс зүйн зөвлөлд танилцуулж, арга хэмжээ тооцуулав. -2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр 03-00/02 дугаар удирдамжаар Говь-Алтай аймгийн Боловсролын газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, зөрчил дутагдал арилгуулах 5 заалттай албан шаардлага хүргүүлэв. -2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын Жэт сургуульд хяналт шалгалт хийж, сураглт эрхлэх тусгай зөвшөөрөл сунгуулах ажил Боловсролын яаманд цахим бүртгэлжилт явагдаж байгаатай холбоотой шийдвэрлэгдээгүй, олон	2-р сар, 3-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					улсын хөтөлбөртэй сургуулийн төлбөр нэмэгдэх асуудлыг өөрийн удирдлагын байгууллага удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэр гаргах тухай Боловсролын багц хуулинд тусгаагүй асуудлуудыг газрын даргад танилцуулж, гомдол гаргасан иргэнд албан бичгээр хариу хүргүүлээ.		
3.1. Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.							
7	Хяналт шалгалт хэрэгжүүлэх аймаг, нийслэлийн хяналтын нэгжийн улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Сургалт зохион байгуулсан тоо Хамрагдсан улсын байцаагч	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 20 Сургалт зохион байгуулсан тоо - 2 Хамрагдсан улсын байцаагч - 60	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 6 Сургалт зохион байгуулсан тоо - 1 Хамрагдсан улсын байцаагч - 30	-2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж батлагдсантай холбогдож, орон нутгийн байцаагч нарт онлайн сургалт хийлээ. - Сүхбаатар, Дархан-Уул аймгийн Боловсролын газрын боловсролын хяналтын улсын байцаагчийн удирдамж, танилцуулга хянаж, арга зүйн зөвлөгөө өглөө. - Дундговь аймгийн Боловсролын газрын боловсролын хяналтын улсын байцаагч ажлын байранд ирж, дадлага хийх үед Төрийн хяналт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					шалгалтын тухай хууль, Боловсролын багц хуулийн холбогдох заалт ашиглах, хяналтын хуудас, эрсдэлийн үнэлгээ хийх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.		
8	Салбарын хяналтын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо	2024 оны гүйцэтгэлийн түвшин	Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна.	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 51.1."Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага эрсдэлийн үнэлгээг харгалзан дараа жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг Хяналт, үнэлгээний үндэсний хороонд ирүүлнэ" гэсэн заалтын дагуу хяналт шалгалтын төлөвлөгөө хүргүүлж, Салбарын хяналтын газрын 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалт хийх объектын жагсаалтыг Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр А/12 дугаар тушаалаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 355 объектод хяналт шалгалт хийхээр батлуулж, яамны ил тод хяналт шалгалт хэсэгт байршуулахаар холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

3.2. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.

9	Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Биелэлтийн хувь	2024 оны гүйцэтгэл	Биелэлтийн хувь - 100%	- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Боловсролын яамны стратеги хөтөлбөрт үндэслэж, Салбарын хяналтын газрын хяналт шалгалтын төлөвлөгөөнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг гаргаж, 7 хоног, сар, улирал, хагас жилээр тайлагнаж байна.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
10	Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг сар, улирлаар тайлагнах	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна. Хэрэгжилтийн тухай тайлагнасан бүр байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө - 2 Тайлагналт - 14	Гүйцэтгэлийн төлөвлөгөө - 1 Тайлагналт - 7	Салбарын хяналтын газрын хяналт шалгалтын төлөвлөгөөг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Хяналт үнэлгээний үндэсний хорооны 02 дугаар тогтоолоор "Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө" батлуулж, Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/12 дугаар тушаалаар "Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					батлуулах тухай" тушаалаар 2025 онд хяналт шалгалтад хамрагдах 355 объект батлуулсан. 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад цэцэрлэг-190 буюу 53,5 хувь, ерөнхий боловсролын сургууль-156 буюу 43,9 хувь, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага-7 буюу 1,9 хувь, дээд боловсрол 2 буюу 0,5 хувийг хамруулж байна.		
11	Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь мэдүүлэх	Хуульд заасан хугацаанд мэдүүлсэн байна.	1	6	Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг эрх бүхий албан тушаалтнаар хянан баталгаажуулж, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд хуулийн хугацаанд нь бүртгүүлсэн.	1-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
12	Төрийн албан хаагчийн чиг үүргийн хүрээнд хариуцаж шийдвэрлэсэн баримт бичгийг	Архивын баримтыг өгсөн хүлээлгэн өгсөн байна.	Хүлээлгэн өгсөн архивын баримт - 4	Хүлээлгэн өгсөн архивын баримт - 6	2024 оны төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтад холбогдох 2 боть материалыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөв	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	зохих хууль, журмын дагуу архивын баримт үүсгэн ТЗУГ-т хүлээлгэн өгөх						үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
13	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх	Өргөдөл, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Шийдвэрлэлтийн хувь - 100%	Шийдвэрлэлтийн хувь - 100%	-МУБИС-ийн нэр бүхий албан хаагчдаас ирүүлсэн гомдлыг удирдах зөвлөлийн даргад танилцуулж, Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн захирлыг ажлаас чөлөөлөх шийдвэр гаргав. -Их Засаг их сургуулийн захиргаа, удирдлага багш ажилчдаас хууль бус цалингаас мөнгө хураасан гомдлыг прокурорын тогтоолоор харьяаллын дагуу ГБХНХЯ-ны СХГ-т шилжүүлэв -Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн суралцагчдаас мөнгө хураасан асуудлыг НБГ-ын боловсролын хяналтын улсын байцаагч шалгасан материалыг татан авч, дахин нягтлан шалгаж, гомдол гаргасан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					эцэг эх, асран хамгаалагч нарт хариу хүргүүлэв. - Баян-Өлгий аймгийн 26 дугаар цэцэрлэгийн эрхлэгчтэй холбоотой асуудлыг шалгуулахаар аймгийн Боловсролын газарт шилжүүлж, хариуг түүгээр нь хүргүүлэв. - Завхан аймгийн Цагаанхайрхан сумын ерөнхий боловсролын сургууль, Чандмань-Эрдэнэ сургуулийн удирдлагатай холбоотой асуудлыг шалгуулахаар аймгийн боловсролын газар, АТГ-т албан бичиг хүргүүлж, гомдол гаргасан иргэнд хариуг түүгээр нь хүргүүлэв		
14	Цаг үеийн нөхцөл шаардлага болон дээд шатны байгууллага, удирдлагаас өгсөн хууль ёсны шийдвэрийн дагуу ажил үйлчилгээг гүйцэтгэх	Цаг хугацаанд нь хийж хэрэгжүүлсэн байна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100%	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100%	-2025 оны 02 дугаар сарын 12-ний өдөр аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 03-00/02 дугаартай удирдамж, 2025-2026 оны хичээлийн жилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх 03-00/03 дугаартай удирдамж боловсруулан батлуулж, хүргүүлэв. -2025 оны 03 дугаар сард ГБХНХЯ-нд Хүүхэд хамгаалалын чиглэлээр Боловсролын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хяналтын гүйцэтгэх үүрэг, хамаарал" мэдээлэл бэлтгэв. -Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн үүргийн дагуу Говь-Алтай аймгийн боловсролын газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийв. - Газрын даргаас өгсөн үүргийн дагуу газрын албан хаагчдын орлон ажиллах ажил үүргийн хуваарь, ээлжийн амралтын хуваарь болон бусад ажил, албан хаагчдын боловсруулсан баримт бичиг хянав		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, дүрэм журмын	Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг,	2024 онд дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад	Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт	-Яамны 14 хоног бүр зохион байгуулж байгаа мэдээллийн цагт бүрэн хамрагдав. -БОУАӨЯ,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чадвараа дээшлүүлэх	мэргэжлийн чадвар дээшилсэн байна.	хамрагдаж, шинжээчийн албан тушаалд тусгай шалгалт өгсөн.	бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Мэргэжлийн чадвараа дээшлүүлнэ.	НҮБ-аас зохион байуулсан "Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээнд боловсролын салбарын гүйцэтгэх гүйцэтгэх үүрэг" хэлэлцүүлэгийн санал дүгнэлт хийхэд оролцож, саналаа өгөв. - Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулахад орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх" хэлэлцүүлэгт оролцож, сүүлийн 2 жилийн дотуур байранд хийсэн шалгалтын дүнг танилцуулж, ажлын хэсэгт ажиллав. -Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан "Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулах явц" хэлэлцүүлэгт оролцов	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 95%
2	Мэдлэг, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим	Яам болон холбогдох газруудаас зохион байгуулсан цахим болон	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт болон Удирдлагын академи, Төрийн	Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна.	-Яамны 14 хоног бүр зохион байгуулж байгаа мэдээллийн цагт бүрэн хамрагдав. -Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	сургалтуудад хамрагдах	танхимын сургалтад хамрагдана.	албаны зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн онлайн сургалтад хамрагдсан.		төрийн албан хаагчийн ёс зүйн онлайн сургалтад хамрагдав	10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 90%
--	------------------------	--------------------------------	--	--	--	------------------------------------	--------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боловсролын салбарын хяналт хариуцсан шинжээч, Дашпунцаг Өнөржаргал /...../

Огноо:

.....